

Шүд Эрүү Нүүрний Эмгэг судлалын Төв

Тус эмнэлэг нь БНМАУ-ын СнЗ-ийн 1986 оны 14 дүгээр тогтоолоор Стоматлогийн поликлиник байгуулах тухай шийдвэр гарч ЭХЯ-ны сайдын тушаал, УБХ-ын АДХГЗ-ны 1986 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 48/75 хамтарсан тушаал, тогтоолоор Стоматологийн поликлиник нэртэйгээр шүдний эмчилгээ, оношлог-оо, эрдэм шинжилгээ, сургалтын нэгдсэн төв болон зохион байгуулагдсан. Тус поликлиникийн анхны даргаар Монголын анхны нүүр, амны их эмч, Нүүр амны Ерөнхий мэргэжилтэн, Анагаах Ухааны дээд сургуулийн анхны багш танхимын эрхлэгч 1956 онд Ленинград хотын Анагаах Ухааны институтийн шүдний эмчийн мэргэжил эзэмшсэн анхны 5 эмчийн нэг Ч.Цэрэндулам /1986-1990 онд томилогдсон. Улмаар их эмч Цэцэгмаа /1990-1994/, /1994-1998/ онуудад анагаах ухааны доктор профессор Б.Оюун бат ажиллаж /1998-2007 он/ хүртэл Н.Пүрэвжав, одоо анагаах ухааны магистр их эмч Д.Чухал Анхны нүүр амны мэс засал, нүүрний эмчилгээ, нүүр амны гажиг согог заслын 3 тасагтай, тасаг бүр нь 5 кабинеттай, насанд хүрэгчид, хүүхдийн үзлэгийн кабинет, ялгавартай байгуулж, туслах кабинет, лаборатори гэсэн бүтэцтэй байгуулагджээ.

Тус эмнэлгийг байгуулах тэр үед ЭХЯ-ны нүүр амны ерөнхий мэргэжилтнээр ажиллаж байсан дэд доктор Ц.Норовлин / одоо "Хүний гавьяат эмч" /Ар оно эмнэлгийн захирал/ түүний тэнхимийн хэн чухал үүрэг гүйцэтгэсэн.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 1997 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11 дугаар тушаалаар Шүд Эрүү Нүүрний Эмгэг Судлалын Төв болон өөрчлөгдсөн. төвийн дүрэм орон тоо нь шинээр батлагдан гарч, нүүр амны эмчилгээ, нүүр амны мэс засал, нүүр амны согог гажиг засал, захиргаа санхүү аж ахуйн, урьдчилан сэргийлэх гэсэн 5 үндсэн нэгжтэйгээр нийт 32 кабинетад үзлэг эмчилгээ хийн үйл ажиллагаа нь өргөжсөн байна.

Өнөөгийн байдлаар "Цахим Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд бүх өрөөнүүдийг интернет цахим сүлжээ, дотоод сүлжээгээр хангасан нь эмчилгээ үйлчилгээнд чанарын шинэ дэвшлийг авчирч байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээнд электрон соронзон картыг нэвтрүүлж байгаа нь үйлчилүүлэгчдийн цаг хугацааг нь хэмнэсэн, сэтгэл, ханамжид нийцсэн, үйлчилгээ болж байна.

ШЭНЭС төвийн эрхэм зорилт

- Урьдчилан сэргийлэлт
- Найдвартай халдвар хамгаалалт
- Чанартай эмчилгээ
- Шуурхай үйлчилгээ

Тус эмнэлэг нь дээрх зорилтын дор нүүр амны эмчилгээ, нүүр амны мэс засал, нүүр амны гажиг согог засал, захиргаа санхүү аж ахуй гэсэн 4 үндсэн нэгжтэй эмчилгээ үйлчилгээний Чанарын алба, Сувилахуйн алба, Төгсөлтийн дараах Сургалтын алба,

гэсэн албатуудтай ба нийт 14 кабинет үзлэг эмчилгээ оношлог-оо хийж, их эмч 23, зөвлөх эмч 5, ерөнхий мэргэжлийн сувилагч 23, шүдний техникч 5 дүрс оношлог ооны техникч 2, захиргаа аж ахуйн 19, ажилтантай нийт 75 хүний бүрэлдэхүүнтэй жилдээ 90,000 мянган хүнд үйлчилж, шүдний эмчилгээ, оношлог оо, эрдэм шинжилгээний сургалтын нэгдсэн үйл ажиллагаатай шүдний төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Монгол улсын төрөлжсөн нарийн мэргэжлийн төв болсон.

Үндсэн үйл ажиллагаа нь шүд цоорох өвчин, түүний хүндрэл, шүдний тойрон эдийн эмгэг, амны салстын өвчнүүд, цөгцний согог, бүрэн шүд гүйдэл, эрүү нүүрний томоохон согогууд, хүүхдийн шүдний ургалтын, эгнээний, эрүүний хөгжлийн гажууд, нүүр амны үрэв сэлт өвчин, гэмтэл, хортой хоргүй хавдар, нүүр амны мэдрэлийн өвчнүүдийг оношлох эмчлэх, дээрх өвчнүүдээс урьдчилан сэргийлэх арга барил болон төгсөлтийн дараах боловсрол олгодог, ЭМШУИС-н НАСС анагаах ухааны коллежийн сургалтын түшиц эмнэлэг юм.

Бүтэц: Чанарын алба, Сувилахуйн алба, НАЭ-ийн тасаг, хүний нөөц,